



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44а,

Утас: 26-21-09, Факс: (976-51) 26-27-37,

E-mail: info@fcy.gov.mn, <http://www.fcy.gov.mn>

2022.06.08 № 01/400
танай _____-ны № _____-т

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН
ДАРГА НАР

Тогтоол, зөвлөмж хүргүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дахь заалтын дагуу Аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн зарим гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг шинээр болон шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 386 дугаар тогтоол "Зөвшөөрөл олгох тухай"-оор зөвшөөрөл авч баталгаажуулан хүргүүлж байна.

Төрийн захиргааны зарим албан тушаалын албан тушаалын тодорхойлолт шинэчлэгдсэнтэй холбогдуулан дараах зөвлөмж, чиглэлийг хүргүүлж байна. Үүнд:

1. Төрийн албаны тухай хуулийн 23.4 "... төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална" гэж заасны дагуу албан тушаал тус бүрээр баталж, тушаал шийдвэрээ 2022 оны 06 дугаар сарын 15-ны дотор muugii.0051@gmail.com хаягаар ирүүлэх,

2. Төрийн албаны тухай хуулийн 23.5-т "... энэ хуулийн 23.3-т заасан тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно" гэж заасан буюу зөрчсөн тохиолдолд үүрэгт ажлаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ хариуцлага тооцохоор заасан тул өөрчлөлт хийхгүй байх,

3. Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага хангахгүй иргэнийг тус албан тушаалд шинээр томилохгүй байх,

4. Одоо ажиллах байгаа албан хаагчдыг цаашид үргэлжлэн ажиллах нөхцөл боломжоор хангаж зохион байгуулалт хийх, /давтан сургах, мэргэшүүлэх, төрийн албаны шалгалт өгүүлэх гм/

5. Сул орон тоо гарсан үед Төрийн албаны тухай хуулийн 22, 23, 26, 27 дугаар зүйл, заалтыг мөрдөх, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2-т заасан тусгай шалгалтыг холбогдох журмын дагуу орон нутгийн Төрийн албаны Салбар зөвлөлд хандаж зохион багуулах,

6. Цаашид салбарын хүний нөөцийг тогтвортой ажиллуулах, мэргэшүүлэх, төрийн албаны чадахуйн зарчим /мерит/ болон Төрийн албаны тухай хууль, тогтоомж, дүрэм журмыг чанд сахиж ажиллах,

Хавсралт хуудастай

ДАРГА

Г.БАТДОРЖ

2000534

D:/Alban bichig folder, A4-2022 doc